227

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХТУЯА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, И-мэйл: letter@moe.gov.mn
Вэб сайт: moe.gov.mn

2024.12.12 № 1/2678

танай 2024.11.21 -ны № 39 -т

Хариу хүргүүлэх тухай

Боловсролын ерөнхий хуулийн зарим заалтын хэрэгжилтийн талаар Танаас ирүүлсэн асуултын хариуг үүгээр хүргүүлж байна.

1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нь Боловсролын ерөнхий хуулийн 33.2.1-д заасны дагуу "багш мэргэжлээр их дээд сургууль төгссөн байх" цорын ганц үндсэн шаардлагыг заасаар байхад Боловсрол судлал /0111/, Нийгмийн ажил /092301/ мэргэжлүүдийг нэмж оруулж ирсэн нь хуульд нийцэж байгаа эсэх:

2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нь нь Боловсролын ерөнхий хуулийн 33.2.2-д заасны дагуу "боловсролын сургалтын байгууллагад тасралтгүй 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагад зургаагаас доошгүй жил тэнхимийн эрхлэгч, албаны дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйчээр дөрвөөс доошгүй жил ажилласан, мэргэжлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх" гэсэн тусгай шалгуурын хэсэгт "захирал" гэсэн албан тушаалыг нэмж оруулж ирсэн нь хуульд нийцэж байгаа эсэх:

Боловсролын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д тус хуулийн 33.2 дахь хэсгийг 2024 оноос хэрэгжүүлж эхлэхээр заасан. Үүнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлөөс Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргад 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 03/532 дугаар албан бичгээр "Боловсролын ерөнхий хуульд орсон нэмэлт өөрчлөлттэй уялдуулан ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах талаар орон нутгийн боловсролын газарт чиглэл өгч, эдгээр албан тушаалын тодорхойлолтод Төрийн албаны зөвлөлөөс санал авах ажлыг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах"-ыг зөвлөсөн байна.

Иймд "Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас бусад боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгчийн албан тушаалын жишиг тодорхойлолт"-ын төслийг боловсруулан Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Албан тушаалын тодорхойлолт батлах нийтлэг журмын дагуу Төрийн албаны зөвлөлөөс санал авсан бөгөөд тус төсөлд Төрийн

14246 1168

албаны зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 03/1183 дугаар албан бичгээр санал ирүүлсэн байна.

Иймд тус саналыг ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын жишиг тодорхойлолтын төсөлд тусган Боловсролын ерөнхий газар болон аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 2/2526 дугаар албан бичгээр хүргүүлсэн. (Албан бичгийг хавсаргав.)

Дээрх албан тушаалын тодорхойлолтын төсөл боловсруулж, хүргүүлэхдээ ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалд тавигдах мэргэжлийн тусгай шаардлагад "Боловсрол судлал /0111"/, "Нийгмийн ажил /092301/" гэж оруулсан нь Боловсролын ерөнхий хуулийн 33.2.1-д заасантай, "боловсролын сургалтын байгууллагад тасралтгүй 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагад зургаагаас доошгүй жил тэнхимийн эрхлэгч, албаны дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйчээр дөрвөөс доошгүй жил ажилласан, мэргэжлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх" гэсэн тусгай шалгуурын хэсэгт "захирал" гэсэн албан тушаал нэмсэн нь тус хуулийн 33.2.2-т заасантай тус тус нийцээгүй байна. Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн саналд дээрх тусгай шаардлагын талаар санал өгөөгүй бөгөөд санал хэсэгт манай яамнаас хүргүүлсэн төсөл дахь шаардлагыг давтан бичсэн байна. (Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийг хавсаргав.)

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Албан тушаалын тодорхойлолт батлах нийтлэг журмын 5.3 дахь хэсэгт заасны дагуу төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн саналыг авсны үндсэн дээр томилох эрх бүхий этгээд эцэслэн батлах тул дээрх албан тушаалын тодорхойлолтын төсөл нь хүчин төгөлдөр эрх зүйн акт биш болно. Түүнчлэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох эрх бүхий албан тушаалтан буюу аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нь ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг хуульд нийцүүлэн эцэслэн боловсруулж, баталж хэрэгжүүлэх боломжтой юм.

Манай яамны зүгээс албан тушаалын жишиг тодорхойлолт боловсруулахад гарсан дээрх алдааг хуульд нийцүүлэн засаж, аймаг, нийслэлийн Боловсролын газруудад хүргүүлэх ажлыг зохион байгуулах болно.

3. Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т "Энэ хуулийн 28.4, 28.5-д заасан албан тушаалд тавих тусгай шаардлага, 33.2-т заасан албан тушаалд тавих тусгай шаардлагыг хангаагүй иргэнийг томилохыг хориглоно."гэж заасан байх тул энэхүү асуултын 1,2 дахь хэсэгт заасан хуулийн зөрчилтэй албан тушаалын тодорхойлолтыг бариимтлан явуулсан захирал, эрхлэгч нарын сонгон шалгаруулалтыг цуцалж, хуульд нийцсэн албан тушаалын тодорхойлолтын дагуу дахин сонгон шалгаруулалт зохион байгуулах боломжтой эсэх:

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 60 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 1.4.3-т "Орон

нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг тухайн аймаг, нийслэлийн Боловсролын газар энэхүү журамд заасны дагуу тус тус зохион байгуулна.", 9.3-т .Удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулахад улс төрийн хүчин, төрийн өндөр албан тушаалтан, төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс Салбар зөвлөлд болон аймаг, нийслэлийн Боловсролын газарт нөлөө үзүүлэхийг хориглоно.", 9.4-т "Төрийн албаны зөвлөл болон Салбар зөвлөл нь энэ журмыг хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангана." гэж тус тус заасан бөгөөд тус журмын 9.5-д "Удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулахтай холбогдсон асуудлаар гарсан энэхүү журмын "нэг"-ийн 4.1-4.3-т заасан эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо шүүхэд гаргаж болно" гэсний дагуу сонгон шалгаруулалтын талаарх гомдлыг холбогдох байгууллагад гаргах боломжтой.

4. Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.5-д "Энэ хуулийн 33.2-т заасан шаардлагыг энэ хуулийн 17.1 дэх хэсэг, 25, 28 дугаар зүйлд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцож болох бөгөөд дүйцүүлэн тооцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж заасны дагуу холбогдох журмыг боловсруулж гаргасан эсэх:

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.5-д "Энэ хуулийн 33.2-т заасан шаардлагыг энэ хуулийн 17.1 дэх хэсэг, 25, 28 дугаар зүйлд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцож болох бөгөөд дүйцүүлэн тооцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж заасныг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн "Журам батлах тухай" А/182 дугаар тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас бусад боловсролын сургалтын байгууллагын ректор, захирал, эрхлэгчийн албан тушаалд тавих тусгай шаардлагыг хуульд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох журам"-ыг баталсан бөгөөд тус тушаал, журмын хуулбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 29 хуудастай.

Л.НАРАНБАЯР

АТА12937 9116621 9024070582

МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141
Утас: 26 42 16, Факс: (976-51) 26 44 60
Цахим шуудан: info@csc.gov.mn

2024.05.28 № 03/1183

танай _____-ны №_____-т

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Х.БАТЖАРГАЛ
ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Тус яамнаас ирүүлсэн Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, насан туршийн суралцахуйн төвийн захирлын албан тушаалын тодорхойлолтын төслийг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-д зааснаар санал авахаар ирүүлснийг салбарын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж, холбогдох саналыг хүргүүлж байна.

Мөн эдгээр албан тушаалтнуудын албан тушаалын тодорхойлолтын хэрэгжүүлэх чиг үүрэгт Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулиудад боловсролын байгууллага, түүний удирдах албан тушаалтны хэрэгжүүлэхээр заасан үүргийг тусгах нь зүйтэй байна.

Хавсралт ..б.. хуудастай.

ГИШҮҮН Б.ПҮРЭВДАГВА

2400271

Төрийн албаны зөвлөлийн
2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн
03/11 дугаар албан бичгийн хавсралт

БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДАХ АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТОД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

	Ерөнхий боловсролын сургуулийн захирал	ТҮБД-5	Саналгүй	Засгийн газраас батлагдсан тухайн салбарын ангилал, зэрэглэл тогтоосон шийдвэрт нийцэж байна.
	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч	ТҮБД-5	Саналгүй	
	Насан туршийн суралцахуй төвийн захирал	ТҮБД-5	Саналгүй	
	Ерөнхий боловсролын сургуулийн захирал	Суралцагчдад ерөнхий боловсрол эзэмшүүлэх, хөгжил, төлөвшлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг чанартай зохион байгуулах тэгш боломж, нөхцөлийг бүрдүүлж дэмжлэг үзүүлэх, байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд суурилан хөгжүүлэх ажлыг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, гүйцэтгэл, үр дүнг, томилсон этгээд, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчийн өмнө хариуцна.	1.Боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.... гэж; 2."Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах; 3.Сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах" гэж хуульд заасан чиг үүргээс тусгах; 4."томилсон этгээд" гэснийг "томилох эрх бүхий албан тушаалтан" гэх	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.5, 33.3.6 дахь хэсэг Мөн Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгаллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулиудад заасан үүргийг тусгах
	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч	Суралцагчдыг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах тэгш боломжоор хангах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг чанартай зохион байгуулах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд суурилан хөгжүүлэх ажлыг	1."Боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх...." гэж; 2.Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах;	

		захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, гүйцэтгэл үр дүнг томилсон этгээд, эцэг эх, асран хамгаалагчийн өмнө хариуцна.	3.Сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах" гэж хуульд заасан чиг үүргээс тусгах; 4."томилсон этгээд" гэснийг "...гүйцэтгэлийн үр дүнг томилох эрх бүхий албан тушаалтан... хариуцна." гэх	
	Насан туршийн суралцахуй төвийн захирал	Боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд насан туршийн суралцахуйн төвийг хөгжүүлэх, албан бус боловсрол болон хүн амын тасралтгүй суралцах, хөгжих үйл ажиллагааг дэмжих, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, менежментийг хэрэгжүүлэх, хувь хүн, нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагад тулгуурласан боловсролын хөгжлийг дэмжих ажлыг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар хангах, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах үр дүнг холбогдох газруудад тайлагнах.	1."Иргэний албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцах мэдээллээр хангах, зөвлөн туслах, удирдах зохион байгуулах ажлыг зохион байгуулах" гэсэн хуулийн заалтыг тодорхой тусгах; 2. "... гүйцэтгэлийн үр дүнг томилох эрх бүхий албан тушаалтны өмнө хариуцна." гэх.	Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг. Мөн Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгаалллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулиудад заасан үүргийг тусгах
Зорилт 5	Ерөнхий боловсролын сургуулийн захирал	1.Ерөнхий боловсролын салбарын хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, явц, үр дүнг тайлагнах; 2.Ерөнхий боловсролын сургуулийн засаглалыг бэхжүүлэх, суралцагч, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа, түншлэлд суурилан байгууллагыг хөгжүүлэх; 3.Багш, ажилтны хөгжлийг дэмжих ажлыг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах; 4.Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах эрүүл, аюулгүй, хамгаалагдсан орчин бүрдүүлэх; 5.Сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийг хангах үйл ажиллагааг тэгш хүртээмжтэй зохион байгуулах, үр дүнг тайлагнах; 6.Байгууллагын төсөв, санхүү, удирдлагыг хэрэгжүүлэх	1. 6 дахь заалтад ... хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, тайлагнах; 2. 7 дахь заалтаар "Хуульд заасан бусад чиг үүрэг хэрэгжүүлэх" гэж тус тус нэмэх	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.5, 33.3.6 дахь хэсэг Мөн Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгаалллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулиудад заасан үүргийг тусгах

	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч	1.Боловсролын болон бусад хууль, тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан байгууллагыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх 2.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах; 3.Хүүхэд бүрд боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх, эрүүл аюулгүй, хөгжлийг нь дэмжсэн орчин бүрдүүлэх ажлыг оролцоонд тулгуурлан зохион байгуулах; 4.Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдийн цогц хөгжлийг дэмжихэд багш, ажилтанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахад шаардагдах сургалтын орчныг бүрдүүлэх; 5.Хүүхэд хамгаалал, хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчинд асрах, хамгаалахад чиглэсэн ажлыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамтын оролцоонд тулгуурлан зохион байгуулах ; 6.Байгууллагын төсөв, санхүүгийн удирдлага болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	1.6 дахь заалтад "... хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, тайлагнах" гэж; 2. 7 дахь заалтаар "Хуульд заасан бусад чиг үүрэг хэрэгжүүлэх" гэж тус тус нэмэх	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.5, 33.3.6 дахь хэсэг Мөн Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгаалллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулиудад заасан үүргийг тусгах
	Насан туршийн суралцахуй төвийн захирал	1.Насан туршийн суралцахуй төвийн НТСТ-ийн талаарх баримталж буй бодлого, эрх зүйн баримт бичгийн төвийн үйл ажиллагааг хүрээнд удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх, үнэлэх төлөвлөх; 2.Түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтран ажиллах; 3.Төвийн төсөв хөрөнгийг оновчтой төлөвлөх, үр ашигтай захиран зарцуулах; 4.Байгууллагын албан хэрэг хөтлөлт, баримтжуулалтын үйл ажиллагааг стандартын дагуу үйлдэх.	1.1-р заалтад Боловсролын салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх гэж нэмэх; 2.1-р заалтын НТСТ-ийн талаарх баримталж буй бодлого, эрх зүйн баримт бичгийн төвийн" гэснийг найруулах, хасах; 3."Иргэний албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцах мэдээллээр хангах, зөвлөн туслах, удирдах зохион байгуулах ажлыг зохион байгуулах" гэсэн хуулийн заалтыг тодорхой тусгах; 4. 4-р заалт.Байгууллагын төсөв, санхүү, хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, тайлагнах гэж нэмэх; 5. 5-р заалтаар "Хуульд заасан бусад чиг үүрэг хэрэгжүүлэх" гэж нэмэх	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.5, 33.3.6 дахь хэсэг Мөн Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгаалллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулиудад заасан үүргийг тусгах

			6."Байгууллагын албан хэрэг хөтлөлт, баримтжуулалтын үйл ажиллагааг стандартын дагуу үйлдэх" гэсэн заалт нь 5-дугаар зориптын хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг тул хасах.	
Боловсрол	Ерөнхий боловсролын сургуулийн захирал	Дээд, бакалаврын болон түүнээс дээш зэрэгтэй байх;	Дээд боловсролтой, Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх гэх.	Дээд боловсролын тухай хууль болон Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолтой нийцэж байна.
	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч	Дээд боловсролтой, бакалавр буюу түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	Дээд боловсролтой, Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх гэх.	
	Насан туршийн суралцахуй төвийн захирал	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй	Дээд боловсролтой, Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх гэх.	
Мэргэжил	Ерөнхий боловсролын сургуулийн захирал	-Боловсролын судлал /011101/; -Багш, бага боловсрол /011301/; -Багш, мэргэжлийн /0114/; -Нийгмийн ажил /092301/.	-Боловсролын судлал /0111/; -Багш, бага боловсрол /011301/; -Багш, мэргэжлийн /0114/; -Нийгмийн ажил /092301/.	
	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч	Багш, сургуулийн өмнөх боловсрол /0112/	-саналгүй	
	Насан туршийн суралцахуй төвийн захирал	Багш /Багш-2330, Нийгмийн ажилтан-2635, Боловсрол сургалтын байгууллагын арга зүйн мэргэжилтэн-2351, Сургалтын менежер-1345/	- Мэргэжлийн индексийг БШУС-н шийдвэрээр батлагдсан мэргэжлийн индекст нийцүүлэх. -Боловсрол /011/; - Нийгмийн ажил /092301/;	Тэгш өрсөлдөх боломжоор хангаж, мэргэжлийн шаардлагыг өргөтгөх боломжийг судлан үзэх
Мэргэшил	Ерөнхий боловсролын сургуулийн захирал	Боловсролын удирдлага, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, төгссөн байх	"мэргэжлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх" гэж нэмэх	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1, 33.2.2 дахь хэсгийг баримтлан мэргэшил хэсэгт тавих шаардлагыг боловсруулах
	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч	Боловсролын удирдлага, боловсрол судлалын чиглэлээр мэргэшсэн байх;	"мэргэжлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх" гэж нэмэх	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1, 33.2.2 дахь хэсгийг баримтлан мэргэшил

				хэсэгт тавих шаардлагыг боловсруулах
	Насан туршийн суралцахуй төвийн захирал	Боловсрол судлал болон удирдахуйн ухааны чиглэлээр мэргэшсэн	Хууль тогтоомжоор тусгайлан заагаагүй шалгуур тавихгүй байхад анхаарах. АТТ-ыг хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулах нь зүйтэй.	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1, 33.2.2 дахь хэсгийг баримтлан мэргэшил хэсэгт тавих шаардлагыг боловсруулах
Туршлага:	Ерөнхий боловсролын сургуулийн захирал	Боловсролын сургалтын байгууллагад тасралтгүй 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагад багшаар зургаагаас доошгүй жил, захирал, тэнхимийн эрхлэгч, албаны дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйчээр дөрвөөс доошгүй жил ажилласан, ~~мэргэжлийн төрүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх~~	"мэргэжлийн төрүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх" гэсэн заалтыг "туршлага" хэсгээс хасаж, мэргэшлийн шаардлага хэсэгт тусгах.	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь хэсгийг баримтлах. 33.5. дахь хэсэгт заасан дүйцүүлэн тооцох журмыг баталж, баримтлах.
	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч	-Хүүхдийн цэцэрлэгт тасралтгүй 10-аас доошгүй жил, үүнээс багшаар зургаагаас доошгүй, арга зүйчээр дөрвөөс доошгүй жил ажилласан байх; ~~-Мэргэшлийн төрүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх;~~	"мэргэжлийн төрүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх" гэсэн заалтыг "туршлага" хэсгээс хасаж, мэргэшлийн шаардлага хэсэгт тусгах.	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь хэсгийг баримтлах. 33.5. дахь хэсэгт заасан дүйцүүлэн тооцох журмыг баталж, баримтлах.
	Насан туршийн суралцахуй төвийн захирал	Боловсролын байгууллагад 10-аас дээш жил ажилласан, удирдах албан тушаалд 5-аас дээш жил ажилласан байх	-Хууль тогтоомжоор тусгайлан заагаагүй шалгуур тавихгүй байхад анхаарах. АТТ-ыг хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулахад анхаарах	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь хэсгийг баримтлах. 33.5. дахь хэсэгт заасан дүйцүүлэн тооцох журмыг баталж, баримтлах.
		Удирдан зохион байгуулах	- боловсролын салбарын статистик, мэдээллийн сан, дүн шинжилгээний аливаа асуудлыг оношлох, шалтгааныг тодорхойлох, задлан шинжлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг оновчтой тайлагнах; - хяналт шинжилгээ үнэлгээ хийх, харьцуулсан судалгааны арга зүйг эзэмшсэн байх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх;	

Ур чадвар	Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, Насан туршийн суралцахуй төвийн захирал		- мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах; - бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах; - бусад.	ТАЗ-ийн 2019 оны 02 дугаар тогтоол болон салбарын бусад хууль, дүрэм журамд нийцүүлэн ур чадварын үзүүлэлтийг нэмэлтээр тусгах боломжтой.
		Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарын эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - аливаа харилцааг зохицуулах арга замыг хууль тогтоомжийн төсөлд тусгах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - аливаа шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг харгалздаг байх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.	
		Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа эерэг мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах; - мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах; - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; - бусад.	
		Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих; - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусад таниулах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх; - үр дүнтэй, нээлттэй харилцаа бий болгох, эргэх холбоотой ажиллах; - иргэд, үйлчлүүлэгчтэй эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцах; - төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх; - компьютерын хэрэглээний программ, интернэт, и-мэйл зэрэг мэдээлэл харилцааны технологийг бүрэн ашиглах чадвартай байх; - төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах	

237

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, И-мэйл: letter@mecs.gov.mn
Вэб сайт: meds.gov.mn

2024.06.11 № 04526

танай_____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГА, АЙМГУУДЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ДАРГА НАРТ

Албан тушаалын тодорхойлолтын төсөл хүргүүлэх тухай

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн болон ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулан Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмын 5.3-т заасны дагуу Төрийн албаны зөвлөлөөс санал авч, ирүүлсэн саналыг тусган Та бүхэнд үүгээр хүргүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмын 5.1-д заасны дагуу чиг үүргийн хүрээнд эцэслэн баталж, холбогдох арга хэмжээ авч ажиллана уу.

Хавсралт 24. хуудас.
Хувийг: Боловсролын ерөнхий газарт

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Х.БАТЖАРГАЛ

14249 2805

Боловсрол шинжлэх ухааны яамны 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 2/2526 дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт

төсөл

ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☑ Төрийн албаны тухай хууль, Боловсролын багц хууль батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан,
☑ Хууль тогтоомжоор албан тушаалын шаардлага, чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Боловсролын ерөнхий хууль
Дагаж мөрдөх огноо:	2024.....
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Хүүхдийн цэцэрлэг	-
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч	Төрийн үйлчилгээний удирдах албан тушаал, ТҮБД-5
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
Ажлын өдөр 8 цаг	Хүүхдийн цэцэрлэг
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	Шаардлагатай үед нэмэлт ачаалалтай ажиллах

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Суралцагчдыг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах тэгш боломжоор хангах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг чанартай зохион байгуулах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд суурилан хөгжүүлэх ажлыг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, гүйцэтгэл, үр дүнг томилсон эрх бүхий албан тушаалтан, эцэг эх, асран хамгаалагчийн өмнө хариуцах

Албан тушаалын зорилт:

1. Боловсролын салбарын бодлого, хууль тогтоомж болон бусад хууль, тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан байгууллагыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх
2. Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

3. Хүүхэд бүрд боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх, эрүүл аюулгүй, хөгжлийг нь дэмжсэн орчин бүрдүүлэх ажлыг оролцоонд тулгуурлан зохион байгуулах;
4. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдийн цогц хөгжлийг дэмжихэд багш, ажилтанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахад шаардагдах сургалтын орчныг бүрдүүлэх;
5. Хүүхэд хамгаалал, хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчинд асрах, хамгаалахад чиглэсэн ажлыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамтын оролцоонд тулгуурлан зохион байгуулах ;
6. Байгууллагын төсөв, санхүүгийн удирдлага болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилтууд	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан Гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Байгууллагын дунд болон богино хугацааны төлөвлөгөөг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, хэрэгжүүлэх, ажлыг удирдан зохион байгуулах, хянаж сайжруулах, тайлагнах;	Байгууллагын үйл ажиллагаа сайжирсан байна.	Г, Х,Ш
	2. Байгууллагын менежментийг сайжруулах бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, түүний хэрэгжилтийг мэргэжлийн түвшинд зохион байгуулахад багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтийн оролцоо, түншлэлийг хангаж ажиллах;	Оролцоонд тулгуурлан боловсруулсан байна	Г, Ш, Х
	3. Боловсролын үйлчилгээний чанар, үр дүнг тооцож хамт олон, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, цэцэрлэгийн зөвлөл, Боловсрол асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад тайлагнах;	Хугацаандаа тайлагнасан байна	Г
	4. Статистик мэдээ, тайланг хугацаанд нь үнэн зөв гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх;	Хугацаа хоцроогүй байна.	Г, Х, Ш
	5. Байгууллагын үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагаа, сургалт, үйл ажиллагааны чанар, үр дүнг тасралтгүй сайжруулах;	Байгууллагын үйл ажиллагаа сайжирсан байна	Г, Ш
	6. Байгууллагын гамшгийн эрсдлийг төлөвлөх, үнэлэх, гамшгийн үед хариу арга хэмжээ авах	стандарт, дүрэм, журмын хэрэгжилт	Ш, Х
	7. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;	Ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	Г, Х, Ш
	8. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих;	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Ш
	9. Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг судлан шийдвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулах;	Шуурхай шийдвэрлэсэн байна.	Г, Х

2 дугаар зорилтын хүрээнд	1. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцон, сургалт, үйл ажиллагааны чанарыг сайжруулахад багшид шаардлагатай мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;	Сургалтын чанар сайжирч, үр дүн гарсан байна.	Т, Х
	2. Багшид ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахад эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн санал, зөвшөөрлийг авч хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;	Эцэг эх, асран хамгаалагчдын саналд тулгуурлан хэрэгжүүлэхэд багшид дэмжлэг үзүүлсэн байна.	Т, Х
	3. Багш, ажилтныг өдөр тутмын арга зүйн удирдлагаар хангах, албан тушаалын тодорхойлолт, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх, боловсролын үйлчилгээг чанартай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, хяналт тавих;	Дэмжлэг үзүүлж үйлчилгээний чанар сайжирсан байна.	Т, Х
	4. Багш, ажилтны мэргэжлийн ур чадварыг тогтмол дээшлүүлж, ажлын байрандаа хөгжих нөхцөлийг бүрдүүлэх;	Хэрэгцээнд нийцсэн техник технологи бүхий орчин бүрдсэн байна.	Ш, Г
	5. Багш, ажилтныг ажлын байрандаа сурч хөгжих, хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдлыг бүрдүүлэх;	Эрүүл аюулгүй, таатай орчин бүрдсэн байна.	Ш, Т
	6. Байгууллагын соёл төлөвшүүлэх, хүүхдийн эрхийг дээдэлсэн, эелтэй, тэгш хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх;	Байгууллагын зөрэг соёл бүрдсэн байна.	Т, Г
	7. Багшийн нэр хүнд, сэтгэл зүй, эрүүл мэндэд хууль бусаар халдах, гутаан доромжлох зэрэг зүй бус үйлдлээс хамгаалах чиглэлээр олон нийтийн түншлэл, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;	Түншлэл, хамтын ажиллагаа хэрэгжсэн байна.	Ш, Г
	8. Багш, ажилтны ажиллах таатай нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох;	Зохион байгуулсан ажлын үр дүн.	Ш, Г, Х
	9. Байгууллагын багш, ажилтныг тогтвортой ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын гүйцэтгэлийг баримт нотолгоонд суурилан бодитой үнэлэх,	шударга, бодитой, үр дүнд чиглэсэн байна.	Г, Ш
	10. Цалин хөлс, шагнал, урамшуулал олгох, хариуцлага тооцох ажлыг холбогдох хууль эрх зүйн баримт бичиг, хөдөлмөрийн гэрээ, **хамтын гэрээ**, байгууллагын дотоод журамд нийцүүлэн хамт олон, эцэг, эх асран хамгаалагчдын саналд үндэслэн бодитой, шударга, үр дүнтэй хэрэгжүүлэх	үнэлгээний соёлыг үйл ажиллагаандаа хэвшүүлсэн байна_	Г, Ш
	11. Багш, ажилтныг хуульд заасны дагуу томилж, чөлөөлөх;	Хуулийн хүрээнд ажилласан байна.	Ш, Г, Х
	1. Сургалтын эрүүл аюулгүй, хөгжлийг нь дэмжсэн орчин бүрдүүлэх ажлын төлөвлөлт, хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж, үр дүнг тооцон сайжруулах;	Үр дүн гарсан байна.	Ш,Г,Х

3 дугаар зорилтын хүрээнд	2. Сургуулийн өмнөх боловсролын үндсэн болон хувилбарт сургалтаар хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүхий эрүүл аюулгүй, хөгжлийг нь дэмжсэн орчин бүрдүүлэх,	Эрүүл аюулгүй, таатай орчин бүрдсэн байна.	Т, Ш
	3. Сургалтыг эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд багш ажилтантай багаар ажиллан мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж, үр дүнг тооцон сайжруулах;	Дэмжлэг үзүүлж зөвлөн тусалсан байна.	Т, Ш
	4. Сургалт, үйл ажиллагаанд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоглоом, хэрэглэгдэхүүн, ном, гарын авлагын хүртээмжийг сайжруулах	Чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн байна	Ш,Г, Х
	5. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний чанар хүртээмжийг сайжруулахад олон нийтийн хамтын оролцоо, түншлэлийг хөгжүүлэх;	Оролцоо, түншлэлийг хангасан байна	Г, Х
	6. Хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан тэгш хүртээмжтэй боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, суралцахуйн түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчныг бүрдүүлэх;	Тэгш хамран сургалтын орчин бүрдсэн байна.	Ш, Т, Х
	7. Цэцэрлэгийн багш, хүүхэд, эцэг эхчүүдийн хэрэгцээнд нийцсэн номын сан байгуулж, номын сангийн тухай хуулийн 10.3-т заасан үйлчилгээ үзүүлэх;	Хэрэгцээнд нийцсэн сургалт, хөгжлийн орчин бүрдсэн байна.	Ш, Г, Х
4 дугаар зорилтын хүрээнд	1. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцон, сургалт, үйл ажиллагааны чанарыг сайжруулах;	Сургалтын чанар сайжирч, үр дүн гарсан байна.	Т, Х
	2. Багш, ажилтныг сургуулийн өмнөх боловсролын үндсэн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэн, үр дүнг тооцон ажиллах;	Хамран сургалт нэмэгдсэн байна	Ш, Х
	3. Багшид ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахад эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн санал, зөвшөөрлийг авч хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;	Эцэг эх, асран хамгаалагчдын саналд тулгуурлан хэрэгжүүлэхэд багшид дэмжлэг үзүүлсэн байна.	Т, Х
	4. Багш, арга зүйчид сургалтын төлөвлөгөө, төлөвлөлт, хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэн, удирдлага арга зүйгээр хангах,	Дэмжлэг үзүүлж сургалтын чанар сайжирсан байна.	Т, Х
	5. Багш, ажилтанд албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх, боловсролын үйлчилгээг чанартай хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд хяналт тавих;	Ажлын гүйцэтгэл сайжирсан байна.	Т, Х
	6. Хамран сургах тойргийн хүүхдийг үндсэн болон хувилбарт сургалтад бүрэн хамруулж сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх ажлыг төлөвлөх, оролцоонд тулгуурлан зохион байгуулах ажлыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;	Хүртээмж нэмэгдсэн байна.	Г,Х, Ш
	7. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон захиргааны байгууллагатай хамтран хамран	Тусгай хэрэгцээт болон 5 настай	Ш, Г, Х

	сургах тойргийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах, таван настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулах;	хүүхдийн 100% хамруулсан байна.	
	8. Гамшиг болон хуульд заасан бусад шалтгааны улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтыг зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсролын агуулгыг нөхөн эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах;	Зайн болон цахим сургалт зохион байгуулагдах боломж бүрдсэн байна.	Ш, Г, Х
5 дугаар зорилтын хүрээнд	1. Цэцэрлэгийн орчинд хүүхэд эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах талаар хүүхэд хамгааллын ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох;	Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжсэн байна	Ш, Т, Х
	2. Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийг чиглүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах, хяналт тавих;	Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжсэн байна	Ш, Т, Х
	3. Хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн, шим тэжээллэг, амин дэмээр баялаг хоол, хүнсний үйлчилгээ үзүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцон сайжруулах;	Хяналт, үр дүнг тооцсон байдал	Ш, Х
	4. Хүүхдийн хоол, хүнсний үйлчилгээ үзүүлэх ажилд эцэг, эх, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх;	Оролцоонд тулгуурлан сайжруулсан байна	Ш, Х
6 дугаар зорилтын хүрээнд	1. Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналттай холбоотой мэдээллийг хамт олон, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид, цэцэрлэгийн зөвлөлд ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар мэдээлэх;	Төсвийн ил тод, нээлттэй байдал хангагдсан байна.	Х, Ш
	2. Байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулах, сургалт, үйл ажиллагааны таатай орчин бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгийг удирдах, зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тооцон ажиллах;	Төсөв, хөрөнгийг оновчтой зарцуулсан байна.	Г, Х
	3. Батлагдсан цалингийн сан, эрх бүхий дээд байгууллагаас баталсан "Хүүхдийн цэцэрлэгийн орон тооны хязгаарын жишиг норм норматив"-т багтаан хүний нөөцийг бүрдүүлж, багш, ажилтны цалин хөлсийг олгох;	Орон тооны хязгаарын жишиг норматив багтаасан байна.	Г, Ш
	4. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд холбогдох байгууллагад тайлагнах,	Стандарт хангагдсан байна.	Х, Ш
	5. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих;	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Ш
	6. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааний төв байгууллага, Боловсрол	Мэдээ, судалгааг	Х, Ш

	асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Боловсрол асуудал эрхэлсэн орон нутгийн байгуулагад шаардлагатай судалгаа, мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх;	хугацаанд нь өгсөн байна.	
	7. Байгууллагын өмч ашиглалт, эзэмшилтэд хяналт тавих, өмч хөрөнгийг зохих журмын дагуу ашиглах;	Оновчтой зохион байгуулсан байна.	Г, Х
	8. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Ш

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
Мэргэжил	Багш, Сургуулийн өмнөх боловсрол /0112/
Мэргэшил	Мэргэшлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх;
Туршлага	Хүүхдийн цэцэрлэгт тасралтгүй 10-аас доошгүй жил, үүнээс багшаар зургаагаас доошгүй, арга зүйчээр дөрвөөс доошгүй жил ажилласан байх;
Ур чадвар	**Багаар ажиллах, удирдан зохион байгуулах чадвар:** - Байгууллагын хөгжлийн дунд болон богино хугацааны төлөвлөгөөг хамтын оролцоонд тулгуурлан боловсруулах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх; - Санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх; - Багш, ажилтны ажил үүргийг оновчтой, тэнцвэртэй хуваарилах, адил тэгш хандах, сэдэлжүүлэх, урам зориг өгөх, дэмжин чиглүүлэх; - бусад
	Дүн шинжилгээ хийх чадвар: - Байгууллагын статистик мэдээ, мэдээллийн санд дүн шинжилгээ хийж аливаа асуудлыг оношлох, шалтгааныг тодорхойлох, задлан шинжлэх - Болзошгүй үр дагаврыг урьдчилан таамаглаж, үйл ажиллагааны боломжит хувилбарыг төлөвлөн хэрэгжүүлдэг байх; - Мэдээлэл болон баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай байх, - Хяналт шинжилгээ үнэлгээ хийх, харьцуулсан судалгаа арга зүйг эзэмшсэн байх;
	Асуудал шийдвэрлэх чадвар: - Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах; - Шийдвэрийн үр нөлөө, үр дагаврыг урьдчилан тооцоолох; - Асуудлыг хууль эрх зүйн хүрээнд байгууллагын зорилго, оролцогч талуудын нийцэл, ойлголцол, оролцоог ханган ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - Харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх; - бусад
	Манлайлах чадвар: - Харилцаа, хандлага, ёс суртахуунаар бусдыг манлайлах; - Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд өөрөө үлгэрлэн манлайлах; - Бүтээлч, санаачилгатай, ажил хэрэгч, хувийн зохион байгуулалт болон ажлын цаг ашиглалтаар хамт олныг үлгэрлэн манлайлах; - Итгэлцлийг бий болгох, багш, ажилтанд адил тэгш хандах, ажлын гүйцэтгэлийг бодитой, шударга үнэлж дүгнэх; - Оролцоонд тулгуурласан, олон нийтийн арга хэмжээнд идэвх, санаачилгаар бусдыг манлайлах; - Бусдын ялгаатай байдал, хэл, соёлын олон талт байдал, хувь хүний онцлог ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг байх; - бусад

	Бусад: - Монгол хэл, найруулга зүйн чадвартай байх, кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - Компьютерын хэрэглээний программ мэдээллийн технологийн дэвшилтэд техник, технологи бүрэн ашиглах чадвартай байх; - Англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх; - Төрийн болон хүний хувийн нууцыг хууль тогтоомжийн хүрээнд хадгалах, хамгаалах;

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГА

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Цэцэрлэгийн нийт багш, ажилтан	Бусад харилцах субъект - Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох албан тушаалтан - Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан - Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага. - Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд - Төрийн болон төрийн бус байгууллагууд - Бага насны хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, иргэд, хуулийн этгээд - Цэцэрлэгийн зөвлөлийн дарга, гишүүд - Бусад цэцэрлэг, сургуулийн захирал, эрхлэгч, багш, ажилтан

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	**Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:**
Албан тушаал: ..... (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20... оны .. дугаар сарын .. -ны өдөр	Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: ..... Дугаар: .....

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: ..... (тамга/тэмдэг)

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ДАРГА .....
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

---oOo---

Боловсрол шинжлэх ухааны яамны 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 2/2526 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ЖИШИГ ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Боловсролын ерөнхий хууль
Дагаж мөрдөх огноо:	2024.08.03, 2024.01.01
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Ерөнхий боловсролын сургууль	-

Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл
Захирал	ТҮБД-5

Ажлын цаг	Ажлын байрны албан ёсны байршил:
Ажлын өдөр 8 цаг	..... аймаг/нийслэлийн ..... сумын/дүүргийн ерөнхий боловсролын сургууль

Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, суралцагчдад ерөнхий боловсрол эзэмшүүлэх, хөгжил, төлөвшлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг чанартай зохион байгуулах тэгш боломж, нөхцөлийг бүрдүүлж дэмжлэг үзүүлэх, байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд суурилан хөгжүүлэх ажлыг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, гүйцэтгэл, үр дүнг томилох эрх бүхий албан тушаалтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчийн өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Ерөнхий боловсролын салбарын хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, явц, үр дүнг тайлагнах.
2.Ерөнхий боловсролын сургуулийн засаглалыг бэхжүүлэх, суралцагч, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа, түншлэлд суурилан байгууллагыг хөгжүүлэх
3.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих ажлыг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах
4.Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах эрүүл, аюулгүй, хамгаалагдсан орчин бүрдүүлэх
5. Сургуулийн орчин дахь хүүхдийн сурч боловсрох, хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийг хангах үйл ажиллагааг тэгш хүртээмжтэй зохион байгуулах, үр дүнг тайлагнах
6.Байгууллагын төсөв, санхүүгийн удирдлага, хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, тайлагнах
7.Хуульд заасан бусад чиг үүрэг хэрэгжүүлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах–Х Шийдвэрлэх–Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Ерөнхий боловсролын салбарын хууль тогтоомж, шийдвэрийг багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчдад ойлгомжтой байдлаар сурталчлан таниулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, явц, үр дүнг тайлагнах;	Хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Г, Х
	2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнах;	Хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Г, Х
	3.Үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг, зорилтот хөтөлбөрт тусгагдсан сургалтын байгууллагад хамаарах зорилт, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, тайлагнах;	Бодлогын хэрэгжилтийг хангаж, үнэн зөв мэдээлэлд тулгуурлан тайлагнасан байна.	Г, Х
	4.Байгууллагын тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;	Бодлогын хэрэгжилтийг хангаж, үнэн зөв мэдээлэлд тулгуурлан тайлагнасан байна.	Г, Х
	5.Тэгш хамруулан сургах, насан туршдаа суралцахуйг дэмжих, цахим шилжилт, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хамаарах хууль тогтоомж, шийдвэр, арга хэмжээ, төлөвлөгөөг талуудын оролцоог хангаж хэрэгжүүлэх ажлыг удирдах, үр дүнг тайлагнах.	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Г, Х

2 дугаар зорилтын хүрээнд	1.Сургуульд суурилсан менежментийг хөгжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах;	Хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Г, Х
	2.Сургууль хөгжүүлэх төлөвлөгөөг багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч болон олон нийтийн оролцоонд суурилан боловсруулан баталж, хэрэгжүүлэх, явц, үр дүнг нээлттэй, ил тод мэдээлэх;	Төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна.	Г, Х
	3.Сургуулийн хэмжээнд мөрдөх хэм хэмжээний акт /дүрэм, журам/ боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоог тэгш хангах, хэрэгжүүлэх ажлыг удирдах, үр дүнг мэдээлэх;	Холбогдох хууль, журмын хүрээнд боловсруулж, мөрдөж ажилласан байна.	Г, Х, Ш
	4.Боловсролын шинэ технологи, инновацын шийдлийг сургуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх;	Хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Г, Х
	5.Байгууллагын үйл ажиллагаанд талуудын оролцоотой өөрийн үнэлгээ хийх, үр дүнд суурилан хариу арга хэмжээ авах төлөвлөлтийг суралцагч, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотой хийж, хэрэгжүүлэх;	Хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Г, Х
	6.Сургуулийн зөвлөл, эцэг, эх, асран хамгаалагчийн төлөөлөл, багш, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагатай хамтран ажиллах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	Холбогдох хууль, журмын хүрээнд хамтран ажилласан байна.	Г, Х
	7.Боловсролын тэгш хүртээмж, чанар, үр дүнг сайжруулах асуудлаар аж ахуйн нэгж байгууллагатай хамтын ажиллагаа, түншлэл хөгжүүлэх;	Холбогдох хууль, журмын хүрээнд хамтран ажилласан байна.	Г, Х
	8.Боловсролын чанар, үр дүнг боловсролын харилцаанд оролцогч талуудад ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар тайлагнах;	Мэдээллийн ил тод байдал хангагдсан байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Багш, ажилтны хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах талаар баримтлах чиглэл, төлөвлөлт хийж хэрэгжүүлэх;	Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байна.	Г, Х

	2.Багш, ажилтан ажлын байранд мэргэжлээ дээшлүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэн багшийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг тодорхой давтамжтай зохион байгуулах ажлыг захиргааны удирдлагаар хангаж ажиллах;	Хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Г, Х
	3.Багш нар мэргэжлийн багаар болон бусад багш нартай хамтран ажиллах, харилцан туршлагаа хуваалцах, хамтдаа хөгжих соёлыг төлөвшүүлэх, багшийн ур чадварт ахиц гаргахад дэмжлэг үзүүлэх;	Дэмжлэг үзүүлж, удирдлагаар ханган ажилласан байна.	Г, Х
	4.Багшийн мэргэшлийн мэдлэг, ур чадварыг мэргэжлийн хөгжлийн бүлэг болон бусад байгууллагын хамтын ажиллагаагаар дэмжих, суралцагч бүрийн оролцоог дэмжсэн идэвхтэй сургалтын болон хичээлийн судалгааны арга зүй, технологид суурилан багшлах ур чадварыг сайжруулах ажлыг зохион байгуулах;	Суралцах, хөгжих орчин бүрдсэн байна.	Г, Х, Ш
	5.Багш, ажилтны ажил үүргийн гүйцэтгэлд хяналт тавих, үйл ажиллагааг үнэлэх, урамшуулах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Г, Х
	6.Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, дотоод үйл ажиллагаа, харилцааны таатай уур амьсгал бүрдүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах;	Байгууллагын соёлыг төлөвшүүлж, багш, суралцагчдын идэвх санаачилга дээшилнэ.	Г, Ш
	7.Багш, ажилтны бүтээлч үйл ажиллагааг сурталчлан таниулах, урамшуулах, шилдэг арга зүй, технологи, менежмент, соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах.	Хууль тогтоомжийн хүрээнд хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Сургууль, анги танхимд суралцахуйн түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий хүртээмжтэй, аюулгүй, хамгаалагдсан, хамтран суралцах сургалтын орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;	Тохируулгат орчин бүрдсэн байна.	Г, Х
	2.Хичээл, сургалтын үйл ажиллагаанд ашиглах сургалтын таблет, компьютер, олон үйлдэлт самбар, техник хэрэгсэл, урвалж бодис, туршилт, дадлагын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл,	Сургалтын материаллаг бааз бэхжсэн байна.	Г, Х, Ш

	сургалтын зохиомол орчин, виртуаль сургалтын талбар үүсгэх хангах ажлыг зохион байгуулж, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах;		
	3.Зайн, цахим, хосолсон сургалт зохион байгуулах техникийн болон сүлжээний дэд бүтцийн бэлэн байдлыг хангах;	Хосолсон сургалт явуулах орчин бүрдсэн байна.	Г, Х, Ш
	4.Багш, суралцагчийн сурч, хөгжих, хамтран ажиллах, мэдээлэл авах үйлийг дэмжихэд чиглэсэн номын сангийн үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах ажлыг зохион байгуулах;	Хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Г, Х
	5.Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик сэтгэлгээг хөгжүүлэх зохион бүтээх хэрэгсэл, төхөөрөмж бүхий орчныг бүрдүүлж хэрэгжүүлэх;	Сургалтын орчин бүрдсэн байна.	Г, Х, Ш
	6.Суралцахуйн төрөл бүрийн хэлбэрийг дэмжсэн, орон зайн хязгаарлалтгүй, уян хатан, анги бүлгээс үл хамааран идэвхтэй, хамтаараа эсхүл ганцаарчлан сурах боломжтой байхаар сургалтын, орчин хувирган өөрчлөх ажлыг зохион байгуулах;	Хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Г, Х
	7.Хичээлийн болон дотуур байр, харилцаа холбоо, цэвэрлэгээ үйлчилгээ болон харуул хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;	Аюулгүй суралцах орчин бүрдсэн байна.	Г, Х, Ш
	8.Сургуулийн орчин дахь хоол, хүнс, ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл ахуйн шаардлагыг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих.	Боловсролын стандартын хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Ш
5 дугаар зорилтын хүрээнд	1.Хамран сургах тойргийн хүүхэд бүрийг сургуульд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж, суралцагч бүрд суралцах тэгш боломж олгох ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах;	Хамран сургах тойргийн суралцагчдыг сургуульд бүрэн хамруулсан байна.	Г, Х
	2. Сургууль дээрх хүүхдийн оролцооны байгууллага, клуб болон суралцагчийн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	Дэмжлэг үзүүлж, удирдлагаар ханган ажилласан байна.	Г, Х

	3.Суралцагчийн ялгаатай байдал, хувийн онцлог, хэрэгцээг хүндэтгэн авьяас, чадвар, сонирхлыг хөгжүүлэх, тэдэнд туслах, дэмжих үйлчилгээг хөгжүүлэх;	Орчин нөхцөлийг бүрдүүлж ажилласан байна.	Г, Х, Ш
	4.Сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлэх;	Суралцах боломжийг бүрдүүлсэн байна.	Г, Х, Ш
	5.Дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах, дотуур байранд амьдарч байгаа хүүхдэд холбогдох хуульд заасан дэмжих үйлчилгээ үзүүлэх ажлыг хэрэгжүүлэх;	Хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Г, Х
	6.Суралцагч сургуулийн орчинд эрүүл мэнд, сэтгэл зүйн болон хоол хүнсний үйлчилгээ авах тохируулга бүхий орчин бүрдүүлж, шаардлагатай дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;	Хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Г, Х, Ш
	7.Суралцагчдад эрүүл, шим тэжээллэг, аюулгүй, хоол, хүнсээр үйлчлэх ажлыг зохион байгуулах;	Эрүүл аюулгүй орчинг бүрдүүлсэн байна.	Г, Х, Ш
	8.Сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалт болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;	Дэмжлэг үзүүлж, удирдлагаар ханган ажилласан байна.	Г, Х
	9.Хүүхдийн эрхийн зөрчил, үе тэнгийн дээрэлхэлт, дарамт, ялгаварлан гадуурхалт, гэмт хэрэг, хорт зуршил, эрсдэлд өртөхөөс сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээ, аюулгүй байдлын зөвлөмж, дэмжлэг үзүүлэх, сургалт, нөлөөллийн арга хэмжээ суралцагчдын дунд зохион байгуулах;	Сургалт, дэмжлэг үзүүлж, удирдлагаар ханган ажилласан байна.	Г, Х, Ш
	10.Суралцагчдын өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	Дэмжлэг үзүүлсэн байдал	Г
	11.Сурах бичгийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, дүрэмт хувцсаар хангах ажлыг холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотой зохион байгуулах.	Хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн байна.	Г, Х, Ш

6 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын төсвийг төлөвлөх, батлуулах зориулалтын дагуу зарцуулах, хяналт тавих, аудит хийлгэх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв, хугацаанд нь тайлагнах;	Батлагдсан төсвийн зориулалтын дагуу захиран, зарцуулж, үнэн зөв тайлагнасан байна.	Г, Х
	2.Хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах;	Хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, Санхүүгийн аудитын дүгнэлтээр зөрчилгүй байна.	Г, Х
	3.Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан байгууллагын ажиллагчдын цалин хөлсийг олгох, санхүүгийн үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэх;	Батлагдсан бүтэц орон, тоондоо ажиллаж, цалин хөлсийг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд олгосон байна.	Г, Х, Ш
	4.Байгууллагын өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хагас, бүтэн жилээр өмчийн тооллого хийлгэх, эд хөрөнгийн бүртгэлийг цахимжуулах, өмч эзэмшигчийн карттай болгох, ашиглалтад нь хяналт тавих;	Өмч хамгаалах зөвлөлийг байгуулан, хяналт тавьж ажилласан байна.	Г, Х, Ш
	5.Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, статистикийн мэдээлэл, бусад шаардлагатай мэдээ, судалгаа, тайланг үнэн зөв гаргах, холбогдох байгууллага, албан тушаалтанд тогтоосон хугацаанд нь мэдээлэх, тайлагнах;	Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн, зөрчилгүй ажилласан байна.	Г, Х
	6.Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг ил тод, нээлттэй, цаг хугацаанд нь мэдээлэх;	Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн хугацаанд нь мэдээлж ажилласан байна.	Г, Х
	7.Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах;	Холбогдох хууль, журмын хүрээнд боловсруулж, мөрдөж ажилласан байна.	Г, Х
	8.Ажлын байранд тавигдах шаардлагад нийцсэн ажилтныг сонгон шалгаруулах, хуульд заасан үндэслэлээр ажилд томилох, ажлаас чөлөөлөх	Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байна.	Г, Х
	9.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ажлыг зохион байгуулах;	Ашиг сонирхлын зөрчилд өртөөгүй байна.	Г, Х
	10.Төрийн албан хаагчдын хувийн хэрэг, мэдээллийн санг баяжуулах, шинэчлэх, архивлан хадгалуулах ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль, журмын дагуу хувийн хэргийг бүрдүүлсэн байна.	Г, Х

7 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн байгууллагын албан хэргийг холбогдох журам, стандартын дагуу хөтлөх, архив бүрдүүлэх ажлыг удирдлагаар хангах, хяналт тавих;	Архивын ажлын үндсэн зааварт нийцсэн байна.	Г, Х
	2.Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, мэдээллийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх, байгууллагын болон хүний хувийн нууцыг хамгаалах;	Хууль, тогтоомжоор батлагдсан ил тод байдлыг шалгуурыг хангаж, ажиллана.	Г, Х
	3.Боловсролын статистик мэдээллийг хянан баталгаажуулах, тогтоосон хугацаанд тайлагнах;	Хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Г, Х
	4.Бусад төрийн байгууллагаас шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээ мэдээллийг шуурхай, чанартай бэлтгэж, хүргүүлэх.	Ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг үнэн зөв мэдээлсэн байна.	Г, Х
	5.Төрийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, Бакалаврын болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	
Мэргэжил	➢ Боловсролын судлал /0111/; ➢ Багш, бага боловсрол /011301/; ➢ Багш, мэргэжлийн /0114/; ➢ Нийгмийн ажил /092301/.	
Мэргэшил	➢ Боловсролын удирдлага, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, төгссөн байх; ➢ Мэргэжлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх;	
Туршлага	Боловсролын сургалтын байгууллагад тасралтгүй 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагад багшаар зургаагаас доошгүй жил, захирал, тэнхимийн эрхлэгч, албаны дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйчээр дөрвөөс доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- Боловсролын салбарын статистик, мэдээллийн сан, дүн шинжилгээний аливаа асуудлыг оношлох, шалтгааныг тодорхойлох, задлан шинжлэх; - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг оновчтой тайлагнах; - Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, харьцуулсан судалгааны арга зүйг эзэмшсэн байх; - Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - Баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх; - Мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах; - Бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах; - Бусад.

	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг баримталж, үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагда, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарын эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - Аливаа харилцааг зохицуулах арга замыг хууль тогтоомжийн төсөлд тусгах; - Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - Гаргасан шийдвэрийн үр дагаврыг хариуцах; - Аливаа шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг харгалздаг байх; - Үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - Бусад.
	Багаар ажиллах	- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа эерэг мэдээллийг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох; - Багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах; - Мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах; - Хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; - Бусад.
	Бусад	- Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих; - Багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусад таниулах; - Кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - Англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх; - Үр дүнтэй, нээлттэй харилцаа бий болгох, эргэх холбоотой ажиллах; - Иргэд, үйлчлүүлэгчтэй зөлдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцах; - Төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх; - Компьютерийн хэрэглээний программ, интернет, и-мэйл зэрэг мэдээлэл харилцааны технологийг бүрэн ашиглах чадвартай байх; - Төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГА

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: -Сургалтын менежер -Багш нар -Нийгмийн ажилтан -Сэтгэл зүйч -Хоол зүйч	Бусад харилцах субъект: - Боловсрол, шинжлэх ухааны яам - Боловсролын ерөнхий газар - Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага - Орон нутгийн ИТХ, ЗДТГ, холбогдох албан тушаалтан - Орон нутгийн харъяа газар, хэлтэс нутгийн

-Үйлчилгээний ажилчид гэх мэт	захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан; - Төрийн болон төрийн бус байгууллага; - Иргэн, хуулийн этгээд.
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах эрхтэй албан тушаалтны шийдвэр:
Албан тушаал: .....: ..... (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2024 оны ... сарын ... -ны өдөр	Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо:..... Дугаар:.....
VI.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:	
Байгууллагын нэр: БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАР Шийдвэрийн огноо: ..... Дугаар:..... (тамга/тэмдэг) ДАРГА ..... (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2024 оны ... дугаар сарын ... -ны өдөр	

255

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 18 өдөр Дугаар А/182 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежоос бусад боловсролын сургалтын байгууллагын ректор, захирал, эрхлэгчийн албан тушаалд тавих тусгай шаардлагыг хуульд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох журам"-ыг хавсралтаар батлалсугай.

2. Журмыг хэрэгжүүлэхэд нэгдсэн арга зүй, удирдамжаар ханган ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Боловсрол, шинжлэх ухааны яамны дэргэдэх салбар зөвлөл (Х.Батжаргал)-д зөвлөсүгэй.

САЙД Л.ЭНХ-АМГАЛАН

14241 0633

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2024 оны 04 дүгээр сарын 18 -ний
өдрийн А/182 дугаар тушаалын хавсралт

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖООС БУСАД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН РЕКТОР, ЗАХИРАЛ, ЭРХЛЭГЧИЙН АЛБАН ТУШААЛД ТАВИХ ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХУУЛЬД ЗААСАН БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАСАН ЖИЛТЭЙ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Боловсролын ерөнхий хуулийн 33.2-т заасан Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежоос бусад боловсролын сургалтын байгууллагын ректор, захирал, эрхлэгчийн албан тушаалд тавих тусгай шаардлагад заасан хугацааг Боловсролын ерөнхий хуулийн 17.1 дэх хэсэг, 25, 28 дугаар зүйлд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцоход энэхүү журмыг баримтална.

Хоёр. Баримт бичигт тавигдах шаардлага

2.1. Иргэн энэхүү журмын 1.1-д заасан байгууллагад ажилласан жилийг дүйцүүлэн тооцуулах хүсэлтээ Төрийн албан зөвлөлийн Боловсрол, шинжлэх ухааны яамны дэргэдэх салбар зөвлөл (цаашид " Салбар зөвлөл" гэх)-д гаргана.

2.2. Иргэн энэхүү журмын 2.1-д заасан хүсэлт гаргахдаа доор дурдсан шаардлагыг хангасан байна:

2.2.1.боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага болон боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн, үнэлгээний, чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн, насан туршийн суралцахуйн төвийн холбогдох албан тушаалд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр баталсан байгууллагын бүтэц, албан тушаалын жагсаалтад заасан үндсэн орон тоонд томилогдон ажилласан байх;

2.2.2.Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэгт заасан ажил олгогчийн шимтгэлийг тухайн иргэнийг томилсон байгууллагаас төлсөн нь цаасан болон цахим баримтаар баталгаажсан байх;

Гурав. Дүйцүүлэн тооцох, баталгаажуулах

3.1.Энэхүү журамд заасан дүйцүүлэн тооцох асуудлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг Салбар зөвлөл хариуцна.

3.2.Салбар зөвлөлийн шийдвэр нь энэ журамд заасан сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд шаардлага хангаж байгаа эсэхийг нотлох баримт бичгийн нэг хэсэг болно.

3.3.Энэхүү журмын 2.2.1-д заасан байгууллагад ажилласан жилийг дүйцүүлэн тооцсон эсэх шийдвэрийг Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн төгтолцоо" цахим системд Салбар зөвлөл бүртгэнэ.

3.4. Дүйцүүлэн тооцсон эсэх мэдээлэл олон нийтэд ил тод байна.

3.5.Салбар зөвлөл нь дүйцүүлэн тооцуулах тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авч, хууль журмын дагуу хянаж, дүйцүүлэх эсэх болон дүйцүүлсэн хугацааг баталгаажуулсан шийдвэрийг 30 хоногийн дотор гаргана.

Дөрөв. Ажилласан жилд дүйцүүлэн тооцох хугацаа

4.1. Журмын 2.2.1-д заасан байгууллагад ажилласан жилийг дор дурдсанаар дүйцүүлэн тооцно:

№	Ажилласан жил	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад		Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад		Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага, боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага, насан туршийн суралцахуйн төв	
		Удирдах албан тушаалд	Гүйцэтгэх албан тушаалд	Удирдах албан тушаалд	Гүйцэтгэх албан тушаалд	Удирдах албан тушаалд	Гүйцэтгэх албан тушаалд
1	Боловсролын сургалтын байгууллагад ажилласан 1 жил	1 жил	50 хувиар тооцно	1 жил	50 хувиар тооцно	1 жил	50 хувиар тооцно
2	Боловсролын сургалтын байгууллагад багшаар ажилласан 1 жил	1 жил	50 хувиар тооцно	1 жил	50 хувиар тооцно	1 жил	50 хувиар тооцно
3	Тэнхимийн эрхлэгч, албаны дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйчээр ажилласан 1 жил	1 жил	50 хувиар тооцно	1 жил	50 хувиар тооцно	1 жил	50 хувиар тооцно

4.2.Иргэн энэхүү журмын 2.2.1-т заасан байгууллагад ажилласан жилээ дүйцүүлэн тооцуулснаар тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцох эрх үүснэ.

Тав. Бусад

5.1. Энэ журмын 4.1-д заасан дүйцүүлэн тооцох хугацааг зөвхөн Төрийн албаны зөвлөлөөс баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх сонгон шалгаруулалтын журам"-ын 2.1.3.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцоход ашиглана.

5.2. Журмын 2.2.1-т заасан байгууллагад ажилласан жилийг дүйцүүлэн тооцох бичиг баримт хуурамчаар бүрдүүлсэн, бичиг баримт бүрдүүлэхэд тусалсан, бусдад давуу байдал олгосон албан тушаалтан, иргэнд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

5.3. Боловсрол, шинжлэх ухааны яамны дэргэдэх Салбар зөвлөл нь санаатай болон санамсаргүй байдлаар хуурамч бичиг баримт үндэслэн журмын 2.2.1-т заасан байгууллагад ажилласан жилийг дүйцүүлэн тооцох шийдвэр гаргасан, бусдад давуу байдал олгосон нь тогтоогдсон тохиолдолд төрийн албаны шалгалт, албан тушаалын томилгоог хүчингүй болгож, буруутай этгээдэд эрүүгийн болон бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр холбогдох байгууллагад шилжүүлнэ.

---000---